

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2016.05

Үзүүлэлтүүд:


<p>ДНБ 3.2% 2016 оны I-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр</p>	<p>ГШХО 4-р сард 51.8 сая ам.доллар</p>	<p>Төсвийн алдагдал -877 тэрбум төгрөг</p>	<p>Инфляци 1.8%</p>	<p>Чанаргүй зээл 1065 тэрбум төгрөг</p>	<p>Валютын нөөц 1.5 тэрбум ам.доллар</p>
<p>Уул уурхайн салбар 130.5 хувь, барилгын салбар 9.4 хувь, хөдөө аж ахуйн салбар 5 хувь тус тус өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 4-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.9 сая ам.доллар, өмнөх сараас 3.7 сая ам.доллараар буурч 58.1 сая ам.доллар болов.</p>	<p>Төсвийн орлого 2085.1 тэрбум төгрөг зарлага 2962.1 тэрбум болж төгрөг, тэнцэл (877) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.</p>	<p>Өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 3.3 өмнөх оны мөн үеэс 1.8 хувь өссөн байна.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 0.8 хувь буюу 9 тэрбум төгрөгөөр буурч 1065 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 9.3% байна.</p>	<p>Монголбанкны валютын нөөц 4-р сард өнгөрсөн оны мөн үеэс 21.8 хувь буюу 277 сая ам.доллараар өсч 1544 сая ам.доллар болов.</p>
<p>\$</p> <p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш</p> <p>1988.53 ₮</p>	<p>House</p> <p>Орон сууцны үнийн индекс</p> <p>1.034</p> <p>Өмнөх сараас 0.05%-иар, өмнөх оны мөн үеэс 11.4%- иар тус тус буурлаа.</p>	<p>Bank</p> <p>Монголбанкны бодлогын хүү</p> <p>10.5 %</p>			



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-гийн урилгаар энэ сарын 18-20-нд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан ёсны айлчлал хийлээ.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2013 он		2014 он		2015 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	18,194	1,116,153	19,482	850,615	14,426	555,027
Төмрийн хүдэр	6725	654,333	8,338	448,378	6,325	227,200
Зэсийн баяжмал	650	948,951	1,378	2,575,636	1,379	2,280,135
Нийт	25,569	2,719,437	29,198	3,874,629	22,130	3,062,362

Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар




Монголбанкны дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөлөөс бодлогын хүүд өөрчлөлт оруулах эсэх асуудлаар хуралдаж, шийдвэр гаргаж мөнгөний бодлогын хүүг 12-оос 10.5 хувь болгон буурууллаа. Энэ жил 2 дахь удаагаа мөнгөний бодлогын хүү буурсан байна.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

ДНБ ДНБ 2016 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 91.3 тэрбум төгрөгөөр өсч эдийн засгийн өсөлт 3.2 хувь болов. ДНБ-ий 3.2 хувиар өсөхөд 130.5 хувиар уул уурхай, олборлох салбар, 9.4 хувиар барилгын салбар, 5 хувиар хөдөө аж ахуйн салбар, 5.4 хувиар үйлчилгээний салбар өссөнөөс шалтгаалсан байна.




Төсөв Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ дөрөвдүгээр сард 2085.1 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 2962.1 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 877 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 1224.6 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 0.6 хувиар буурч, зарлага 21.1 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.



Валютын ханш Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 49.2 төгрөг буюу 2.5 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 23.4 төгрөг буюу 1.2 хувиар буурч 1988.53 төгрөгөөр сулрав. Сүүлийн 2 саруудад 60 төгрөгөөр ам.долларын ханш буурсан үзүүлэлттэй байна.




Инфляци Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 5-р сард өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 3.3 хувь өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 4-р сард өмнөх оны мөн үеийнхнээс 1.8 хувиар өсөхөд 69.8 хувь нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс, 26.3 хувь нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.




* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаад валютын нөөц Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 4-р сарын байдлаар 1544 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 22 хувь буюу 279 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 21.8 хувь буюу 277 сая ам.доллараар өссөн байна.



* Эх сурвалж Монголбанк


MSE-20 индекс 2016 оны тавдугаар сард 37.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 0.5 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 9.1 тэрбум төг буюу 19.5 хувь, арилжигдсан үнэт цаас өмнөх сарынхаас 9.7 сая ш буюу 94.9 хувиар буурчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны 5 дугаар сард 10882 нэгж болж, өмнөх сарынхаас 137 нэгж, өмнөх оны мөн үеийнхээс 1923 нэгжээр буурчээ.



*Монголын хөрөнгийн бирж


Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2016 оны тавдугаар сарын эцэст 10.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 140.8 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 813 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар өсөв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 788 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 43.2 тэрбум төгрөг буюу 5.8 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 5.3 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар буурав.



Хадгаламж

Нийт хадгаламж 2016 оны 5-р сард 7.8 их наяд төгрөг болж өмнөх сараас 143.5 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 651.3 тэрбум төгрөг буюу 9.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү, өмнөх оны мөн үеэс нийт хадгаламж өсөхөд валютын хадгаламж 14.5 хувиар буюу 278.7 тэрбум төгрөгөөр өсч, төгрөгийн хадгаламж 7.2 хувиар буюу 651.3 тэрбум төгрөгөөр өсчээ.



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны тавдугаар сарын байдлаар 11.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 198 тэрбум төгрөг буюу 1.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 738 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар буурав. Харин чанаргүй зээлийн хэмжээ 1065 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.8 хувь (9 тэрбум төгрөг)-иар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 44.2 хувь (327 тэрбум төгрөг)-иар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.3 хувийг эзэлж байна.



Ипотекийн зээл

2016 оны 4-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.9 хувь (67.6 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 17.9 хувь (550.3 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.6 их наяд төгрөгт хүрэв. Дөрөвдүгээр сард нийт 1305 зээлдэгчид 67.7 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 82320-д хүрэв. 2016 оны 4 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэлийн 98.9 хувь нь төгрөгийн зээл, 1.1 хувь нь гадаад валютын зээл байна.




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа

2016 оны тавдугаар сард худалдааны нийт бараа эргэлт 2946 сая ам.доллар, үүнээс экспорт 1774 сая ам.доллар, импорт 1172 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 602 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 370 сая ам.доллар буюу 11.1 хувь, үүний дотор экспортын хэмжээ 94.7 сая ам.доллар буюу 5 хувиар, импортын хэмжээ 275 сая ам.доллар буюу 19 хувиар тус тус буурчээ. Үүнд, эрдэс бүтээгдэхүүний импорт 141.5 сая ам.доллар, үндсэн төмөрлөг бүтээгдэхүүнийх 82.3 сая ам.доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 26.7 сая ам.доллар, хүнсний бүтээгдэхүүнийх 11.2 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Гадаад худалдаа




* Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2016 оны дөрөвдүгээр сард 58.1 сая ам.долларын эерэг үр дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 51.9 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад 3.7 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -0.9 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 59.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт



* Эх сурвалж Монголбанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2016 оны нэгдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 22.5 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 11 хувь (387 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 5 хувь (995 сая ам.доллар) аар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 18 хувийг засгийн газрын өр, 9 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 48 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 97 хувийг богино хугацаат, 3 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Үзүүлэлтүүд	Тэрбум төгрөг			
	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл	S&P		Fitch	
	Монгол Улс	В Тогтвортой	В	Сөрөг
Огноо	2015.11.05		2013.12.13	

Standard & Poor's Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 11-р сард "B+" зэрэглэлээс "B" зэрэглэлд болгож бууруулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтооходоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's 2014 оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

- 05.06 Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын XIV хуралдаан болж, Монгол Улс, БНХАУ-ын Замын-Үүд Эрээний боомтод хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлаар Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат болон БНХАУ-ын Худалдааны сайд Гао Хучөн нар хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.
- 05.07 "Оюу толгойн" гүний уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг компанийн хувьцаа эзэмшигчид болох "Рио Тинто" компани, Монгол Улсын Засгийн газар, "Туркойз Хилл Ресурс" компаниуд 5.3 тэрбум ам.доллараар баталсан байна.
- 05.12-13 АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалт энэ сарын 12-13-нд Улаанбаатар хотноо болж уулзалтад АСЕМ-ын түнш 51 улс, Европын холбоо, Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН)-ийн НБДГ-аас гадна Ази-Европын сангийн төлөөллөөс бүрдсэн нийт 170 төлөөлөгч оролцов.

Тойм

Бөөрөлжүүтийн нүүрсний уурхай, цахилгаан станцын цогц төслийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдав.

Улаанбаатар хотоос 120 км зайд Төв аймгийн Баянжаргалан сумд орших Бөөрөлжүүтийн нүүрсний уурхай, цахилгаан станцын цогц төслийн Засгийн газар болон Хөрөнгө оруулагчдын хооронд хөрөнгө оруулалтын гэрээ, цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээнд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ болов. Тус орд нь 2019 оноос жилдээ 1.6 тэрбум квт.цаг буюу манай улсын нийт эрчим хүчний хэрэглээний 30 хувийг үйлдвэрлэх бөгөөд 2019 онд эхний ээлжийн 300 мвт-ыг ашиглалтад оруулах бол 2022 оноос 3.2 тэрбум квт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай болох юм. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Эрчим хүчний хэрэглээний 20 орчим хувийг ОХУ-аас өндөр үнээр импортолдог байсныг дотоодын хямд үйлдвэрлэлээр орлуулж, 2019 он хүртэл 1.1 тэрбум ам.долларын валютын урсгал нэмэгдэж, 300-гаад ажлын байр бий болох зэргээр нийгэм, эдийн засгийн томоохон ач холбогдолтой.

Монголбанкны дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөлөөс бодлогын хүүд өөрчлөлт оруулав.

Монголбанкны дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөлөөс бодлогын хүүд өөрчлөлт оруулж мөнгөний бодлогын хүүг 12-оос 10.5 хувь болгон буурууллаа. "Өнгөрсөн сарын эцэст хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн жилийн инфляци 1.7 хувь болж, сүүлийн 9 сарын турш зорилгот түвшнээс доогуур байна. Энэ оны туршид нийлүүлэлтийн гаралтай болон эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт бага байх төлөвтэй байгаа нь нам, тогтвортой инфляцийг хадгалахад эергээр нөлөөлнө. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөв эерэг байхын зэрэгцээ 2016 онд төлбөрийн нийт тэнцэл алдагдалгүй байх төсөөлөлтэй байна. Макро эдийн засгийн гадаад тэнцвэрт гарч буй эерэг өөрчлөлтүүд нь мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх орон зайг нэмэгдүүллээ. Гэхдээ макро эдийн засгийн "шинэ тэнцвэр"-ийг хангах зорилтын хүрээнд улсын төсвийн зардлыг орлогын гүйцэтгэлтэй нь уялдуулан хязгаарлах, улсын төсвийг алдагдалгүй байлгах шаардлага хэвээр байна. Мөнгөний бодлогын төлвийг зөөлрүүлэх энэхүү шийдвэр нь мөнгө, зээлийн өсөлт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн идэвхжилийг дэмжихэд эергээр нөлөөлнө" гэж Монголбанкны ерөнхийлөгч мэдэгдэв.